

ГХБХБГ-ЫН 5 ДУГААР САРЫН 3 ДАХЬ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

2018.05.17.

ӨЛГИЙ СУМ

| 7 хоногийн ажлын товч мэдээлэл | дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал | бусад асуудал |
|---|--|----------------------|
| <p>Өлгий сумын 4-р багийн айл, өрхүүдийг цэвэр усны шугам сүлжээнд холбох ажилд хяналт тавин ажиллаж байна. Одоогийн байдлаар гүйцэтгэл нь 70 хувьтай байна.</p> <p>Өлгий сум 13-р багт хийгдэх гэрэлтүүлгийн ажлын зураггүй тул ажил эхлүүлэх зөвшөөрөл олгоогүй.</p> <p>Аймгийн төвийн зарим нийтийн орон сууцны орчны газрыг шинэчлэн тогтоох ажлын комиссыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулж газар дээр нь үзлэг шалгалт, судалгаа хийж комисст танилцуулахад бэлэн болгов.</p> <p>8-р багт шинээр баригдаж байгаа Хүүхдийн дэлгүүр, Мөн 5-р багт 15 айлын орон сууц, 13-р багийн иргэн Хуатын хувийн орон сууц, Толбо Жай ХХК-ний тоосго, элс, хайрга , бетоны үл эвдэх нийтдээ 16 төрлийн барилгын материалд шинжилгээ хийсэн.</p> <p>Аймагт баригдаж байгаа барилга болон барилгын материалын үйлдвэрүүдэд мэдэгдэх хуудас өгсөн болно.</p> <p>2018 оны 05-р сарын 16-ний өдрөөс 5 хоног УБ хотоос ирсэн ArcGIS-ийн мэргэжилтэн Б.Даваамөнх ГХБХБГ-ын мэргэжилтэн болон сумын газрын даамал нарт ArcGIS-ийн төлбөртэй сургалтыг зохион байгуулж байна.</p> | | |

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР